



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2015 оны 01 сарын 21 өдөр

Дугаар 35

Улаанбаатар хот

“Өмгөөллийн Эй Эм партнерс” ХХН-ийг  
үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө  
үзүүлэх хуулийн этгээдээр бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.15, 24.3, Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 451 дүгээр тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдийг бүртгэх тухай журам”-ын 4.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Өмгөөллийн Эй Эм Партнерс” ХХН-ийг үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдээр бүртгэсүгэй.
2. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Өмгөөллийн Эй Эм Партнерс” ХХН /Ж.Ариунаа/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Ц.Энхбаяр/-нд даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

030500